



СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Э.СОНИНТОГОС ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.23 № 3/513
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Соёл урлагийн их сургуулийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Соёл урлагийн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ”-ИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын
газрын дарга Ц.Наранчимэг
Цахим хаяг:
Naranchimegts@audit.gov.mn
Утас: 261663

Аудитын менежер Я.Самбууням
Цахим хаяг:
Sambuunyamy@audit.gov.mn
Утас: 260512

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим
хаяг:serjmyadagb@audit.gov.mn

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Баян ташаагийн эх” аудит ХХК-ийн
Захирал Т.Хоролсүрэн
Утас:99116028, 99062255
Аудитор:С.Оюунцэцэг
Аудитор:Д.Түмэндэмбэрэл

Хаяг: БГД 4 хороо, 2-р хороолол,
П.Жасрайн гудамж 24/1 байр, 6,7
тоот Имайл хаяг:
bte.audit@yahoo.com
2017 оны 03 дүгээр сарын 09

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2 Аудитын тайлан
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлыг тооцсон тухай
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Соёл урлагийн их сургууль”-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ./ҮАГ-2017/278/СТА-ТШЗ/

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын ОлонУлсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Соёл урлагийн их сургууль”-ийн 2016оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Соёл урлагийн их сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 24-өөс 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн “Баян ташаагийн эх” аудит ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв.

“Соёл урлагийн их сургууль”2016 оны санхүүгийн тайлангаа 2017 оны 2дугаар сарын 24-нд 03/339тоот албан бичгээр “Баян ташаагийн эх” аудит ХХК-д ирүүлсэн байна. Аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд “Соёл урлагийн их сургууль”-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Соёл урлагийн их сургууль”-ийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль,бусад холбогдолтой хууль, эрх зүйн актын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, дээрх зарим хуулинд нэмэлтөөрчлөлт орсон.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Соёл урлагийн их сургууль” Хөгжмийн урлагийн сургууль, Театрын урлагийн сургууль, Дүрслэх, дизайны урлагийн сургууль, Радио, телевиз медиа урлагийн сургууль, Соёлын сургууль, Бүжгийн урлагийн сургууль гэсэн бүтцийн 6 сургууль, салбар сургууль болох Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж, Соёл урлаг судлалын хүрээлэн, Бадмаараг ахлах сургууль, 24 тэнхим, 9 профессорын баг, 4 төв, захиргааны 5 газар, 315 багш судлаач, 204 ажилтан, ажилчид, 4511 бакалавр, магистрант, докторант оюутан,сурагчтай сургалт, эрдэм шинжилгээ, урлагийн бүтээлийн үйл ажиллагаа явуулсан байна.

“Соёл урлагийн их сургууль”-ийн эрхэм зорилго нь Монголчуудын уламжлалт соёл, урлагийн үнэт зүйлийг орчин үеийн дэвшилтэт ололтой хослуулан эзэмшсэн, дэлхийн урлагт хуримтлуулсан мэдлэгээс суралцсан дэлхийн соёл, урлагт хувь нэмрээ оруулан, Монголын соёлыг хүн төрөлхтний өвийн салшгүй хэсэг болгож чадах мэргэжилтэн, судлаач, уран бүтээлч бэлтгэнэ.

Нийгмийн эрэлтэд тулгуурлан сургалтын стандартад нийцүүлэн диплом, бакалавр, магистр, докторын зэрэг олгох, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх, хос хавсрага хөтөлбөрөөр сургалт эрхэлж, мэргэжлийн болон иргэний өндөр боловсрол, чадвартай мэргэжилтэн бэлтгэх, шинэ мэдлэг бүтээж, сургалт судалгааны эргэлтэнд оруулах, нийтэд түгээх, нийтийн соёл, мэргэжлийн урлагийн түвшнийг дээшлүүлэхэд үндсэн чиг үүрэг оршино.

Дээрх зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу сургуулийн захирал Э.Сонинтогос төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. “Соёл урлагийн их сургууль”-ийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Соёл урлагийн их сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлангийн уялдаа тохиргоог шалгаж, мөнгөн гүйлгээний зарим дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилийг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Соёл урлагийн их сургууль”-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг захирлын 2015 оны А/148 тоот тушаалаар батлуулан мөрдөж байна. Уг бодлогын баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар, арга, аргачлалыг тусгаагүй УСНББОУ, Сангийн сайдын 388, 5, 55 дугаар тушаалуудаар батлагдсан заавар журамтай нийцэхгүй байна.

“Соёл урлагийн их сургууль”-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Соёл урлагийн их сургууль”-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох компанийн “Acolous” програмаар

боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуусанхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлыг тооцсон тухайд:

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг батлагдсан төсөв 12,232.9 сая төгрөгийг суурь болгон 1.5 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 183.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолж төсвийн гүйцэтгэлийн нийт зардал 10,053.1 сая төгрөгийн 1 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 150.8 сая төгрөг гэж тооцов.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Соёл урлагийн их сургууль”-ийн дотоод хяналт эрсдэлийг бага гэж тооцсон ба дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

ТУЗ-өөр батлуулсан 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавинажилласан байна.

“Соёл урлагийн их сургууль”-ийн төсвийн захирагч нь зардлыг санхүүжүүлэх орлогын эх үүсвэр 12,232.9 сая төгрөг батлагдснаас гүйцэтгэлээр 9,936.2 сая төгрөг гарч 81.2 хувийн биелэлттэй байгаа нь орлогын төлөвлөгөөнд урьд оны дансны үлдэгдлээс зарцуулах 2,680.1 сая төгрөг батлагдсантай холбоотой байна. Мөн урсгал зардалд 12,232.9 сая төгрөг батлагдсанаас 10,053.1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсанаас 2,304.3 сая төгрөгийг дутуу буюу төсвийн гүйцэтгэл 81.3 хувьтай байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитаар 13 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 25 нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Соёл урлагийн их сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, завсрын болон жилийн эцсийн аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар, эрдэм шинжилгээ, хичээл үйлдвэрлэлийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 60 хувь, мөнгөн хөрөнгийн 80 хувь, нийт зардлын 70 хувь, нийт хөрөнгийн 60 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийгшийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дараахалдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

1. Төв сургуулийн тооцооны нягтлан бодогч нь кассын няравын ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.7-д Мөнгөн кассын няравт дараах ажиллагааг хориглоно, 3.7.3-т Мөнгөн кассын тооцооны ажилтай шууд холбогдол бүхий ерөнхий болон тооцооны нягтлан бодогч зэрэг хүмүүсийг мөнгөн кассын няравын ажлыг давхар гүйцэтгэх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Кассын нярвайн ажлыг нягтлан бодогчоор давхар гүйцэтгүүлэхгүй байх, санхүүгийн ажилтнуудын дотоод хяналтыг сайжруулахад арга хэмжээ авч ажиллахыг завсрын аудитаар менежментийн захидал хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

2. Тус сургуулийн эдийн засагч нь дотоод аудитын ажлыг хавсран гүйцэтгэдэг бөгөөд Захиргаа хяналт шинжилгээ үнэлгээний газрын журмыг баримтлан ажилладаг байна. 2016 оны ажлын төлөвлөгөөг сургуулийн захирлаар батлуулсан ба тус төлөвлөгөөнд цалин, сургалтын төлбөрийн төлөлт, өр авлагын асуудлыг багтаажээ. Харин сургалтын төлбөртэй холбоотой асуудаар хяналт шалгалт хийгдээгүй, зарим асуудлаар хийгдсэн хяналт шалгалтын тайлан байгаа ч төлөвлөгөөний биелэлт дүгнэгдээгүй байна.

Шийдвэрлэсэн: Дотоод аудитор нь тайланд жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хамруулан, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж үр дүнгээ дүгнүүлж ажиллах. Дотоод аудиторын хараат бус байдлыг хангах тал дээр арга хэмжээ авч ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Хичээл үйлдвэрлэлийн зардалд амралтын газрын хоол, аж ахуйн материал, бүжгийн хувцас, ном хэвлүүлэхэд гарсан зардал гэх мэт нийт 82.2 сая төгрөгийн зардлыг бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан бараа материалын бүртгэлийн дансны заавраар бүртгэж хөтлөөгүй, УСНББОУС 12 "Бараа материал" стандартын 44 дүгээр зүйлд зааснаар "бараа материалыг борлуулах солилцох буюу хувиарлах үед тэдгээр бараа материалын дансны үнийг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв холбогдох орлого байхгүй бол барааг хувиарлах буюу холбогдох холбогдох үйлчилгээг үзүүлэхэд гарсан зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан бараа материалын бүртгэлийн дансны зааврын дагуу бараа материалыг бүртгэх, холбогдох стандарт мөрдөх. Зөвлөмж хүргүүлэв.

4. Төв сургууль нь цахим програмын үнэ 4.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд зардалд бүртгэсэн байгаа нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө 13-д а) "Бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэнд, бусдад түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийг зардлаар бүртгэхгүй байх, хөрөнгийг данс бүртгэлд тусгах, холбогдох стандарт мөрдөн ажиллах. Зөвлөмж хүргүүлэв

5. Тайлант онд үр дүнгийн тайлангийн орлогоос нийт 2,030.7 сая төгрөгийн орлого бууруулан тайлагнасан байна. Эдгээр нь улсын төсвөөс санхүүжих сургалтын төрийн сан болон, тогтмол зардлын санхүүжилтийн орлогыг бүтцийн сургуульд шилжүүлэхдээ орлогоос бууруулсан бичсэн 441.4 сая, сургалтын төлбөрийг орсон тухай бүр нь орлогоор бүртгэн авлага, УОО-ын үлдэгдлээр орлогыг бууруулсан болон суртгалтын төлбөрийн буцаалтаас нийт 1,497.3 сая, бусад орлого болон хөрөнгийн дотоод хөдөлгөөнөөс 91.4 сая төгрөг тус тус байгаа нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккурэл сууриар бүртгэж, тайлагана", Сангийн сайдын баталсан 388, 5, 55 дугаар тушаалуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн:Төв болон бүтцийн сургуулийн хооронд гарсан ажил гүйлгээ олон сургалтын төлбөрийг холбогдох стандарт, хууль, журмийн дагуу үнэн зөв бүртгэж тайлагнах, Зөвлөмж хүргүүлэв

6. Мөнгөн гүйлгээний тайланд нийт 233.1 сая төгрөгийн орлого бууруулах бичилт хийснээс 29.1 сая төгрөг нь орлогоос буурууж зардал гаргасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах"- гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Орлого бууруулан зардал гаргахгүй байх, холбогдох стандарт, хууль, журам мөрдөж ажиллах Зөвлөмж хүргүүлэв.

7. Захирлын 2014 оны 191 дугаар тушаалаар докторын зэрэгтэй үндсэн багш, ажилтанд Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам"-ын 3 дугаар хавсралтаар баталсан эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгохоос гадна "СУИС-ын доктор"-ын нэмэгдлийг үндсэн цалингийн 15 хувиар тооцож олгохоор баталж тус нэмэгдлийг цалингийн санд докторын зэрэгтэй 41 багш, алжиланд 46.1 сая төгрөгийг олгосон байгаа нь "Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам"-ыг зөрчсөн

Шийдвэрлэсэн:"Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам"-д заагаагүй цалингийн нэмэгдэл олгохгүй байх завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж холбогдох тушаалыг хүчингүй болгосон байна.

8. Захирлын 2015 оны А/148 дугаар тушаалаар "СУИС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горим"-ыг батлан мөрдөн ажиллаж байгаа боловч тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар, арга, аргачлалыг тусгаагүй байна энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг "; 18 дугаар зүйлийн 18.2-т "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь:УСНББОУС болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын журамд үндэслэн өөрийн байгууллагын онцлогийг тусгасан НБББББ боловсруулан мөрдөж ажиллах. Зөвлөмж хүргүүлэв.

9. Хуримтлагдсан элэгдлийг 86.8 мянган төгрөгөөр дутуу, ном боруулсны орлого 6.8 сая төгрөгийг бараа материал худалдсны олзоор, үнэ төлбөргүй хүлээн

авсан 121.2 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан олзоор тус тус бүтгэсэн байна.

Шийдвэрлэсэн:Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан

Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Аудитаар нийт128.1сая төгрөгийн алдаа илэрснээс 128.1сая төгрөгийн алдааг залруулж залруулагдаагүй алдаа гараагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Соёл урлагийн их сургууль”-ийн2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Соёл урлагийн их сургууль”-ийн2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт290.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 128.1 сая төгрөгийг санхүүгийн тайланг залруулж, 162.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.Бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн 82.2 сая сая төгрөгийн зөрчлийг материаллаг бус гэж үзлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Санхүүч аудит ХХК-аас 4 зөвлөмж өгсний 3-ыг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжүүлэгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Соёл урлагийн их сургууль”-ийн2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан9хуудас, менежментийн захидал4хуудсыг тус тус хавсаргав.

Огноо: 2017.03.10



“СУИС”-ИЙН 2016 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Асуудал 2

Дотоод аудиторын талаар

Асуудал 3

Орлого үр дүнгийн тайлагналын талаар

Асуудал 4

Шууд зардлаар бүртгэсэн бараа материалын талаар

Асуудал 5

Үндэслэлгүй олгосон цалингийн нэмэгдлийн талаар

Асуудал 6

Мөнгөн гүйлгээний тайлагналын талаар

Асуудал 7

Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн талаар



Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг СУИС-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Соёл урлагийн их сургуулийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Захирлын 2015 оны А/148 дугаар тушаалаар "СУИС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горим"-ыг батлан мөрдөн ажиллаж байгаа боловч тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар, арга, аргачлалыг тусгаагүй байна энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг "; 18 дугаар зүйлийн 18.2-т "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан холбогдох стандарт, дүрэм журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын журамд үндэслэн өөрийн байгууллагын онцлогийг тусгасан НБББББ боловсруулан мөрдөж ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

2017 оны эхний хагас жилд багтаан УСОУНББС-д нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох хууль журам болон байгууллагын онцлогийг тусгасан НБББББ-ийг боловсруулан мөрдөн ажиллана.

ҮАГ-ын ажиглалт

Тус сургуулийн эдийн засагч нь дотоод аудитын ажлыг хавсран гүйцэтгэдэг бөгөөд Захиргаа хяналт шинжилгээ үнэлгээний газрын журмыг баримтлан ажилладаг байна. 2016 оны ажлын төлөвлөгөөг сургуулийн захирлаар батлуулсан ба тус төлөвлөгөөнд цалин, сургалтын төлбөрийн төлөлт, өр авлагын асуудлыг багтаажээ. Харин сургалтын төлбөртэй холбоотой асуудаар хяналт шалгалт хийгдээгүй, зарим асуудлаар хийгдсэн хяналт шалгалтын тайлан байгаа ч төлөвлөгөөний биелэлт дүгнэгдээгүй байна.

Эрсдэлүүд

Дотоод хяналт сулрах, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл нэмэгдэх, хараат бус байдал алдагдах

ҮАГ-ын зөвлөмж

Дотоод аудитор нь тайланд жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хамруулан, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж үр дүнгээ дүгнүүлж ажиллах. Дотоод аудиторовын хараат бус байдлыг хангах тал дээр арга хэмжээ авч ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитын зөвлөмжийг хүлээн авч 2017 оны төсвийн тодотголд дотоод аудиторовын орон тоог тусган, Удирдах зөвлөлд санал хүргүүлэн ажиллах болно.

Асуудал 3: Орлого үр дүнгийн тайлангийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд үр дүнгийн тайлангийн орлогоос нийт 2,030.7 сая төгрөгийн орлого бууруулан тайлагнасан байна. Эдгээр нь улсын төсвөөс санхүүжих сургалтын төрийн сан болон, тогтмол зардлын санхүүжилтийн орлогыг бүтцийн сургуульд шилжүүлэхдээ орлогоос бууруулсан бичсэн 441.4 сая, сургалтын төлбөрийг орсон тухай бүр нь орлогоор бүртгэн авлага, УОО-ын үлдэгдлээр орлогыг бууруулсан болон суртгалтын төлбөрийн буцаалтаас нийт 1,497.3 сая, бусад орлого болон хөрөнгийн дотоод хөдөлгөөнөөс 91.4 сая төгрөг тус тус байгаа нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккурэл сууриар бүртгэж, тайлагана", Сангийн сайдын баталсан 388, 5, 55 дугаар тушаалуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төв болон бүтцийн сургуулийн хооронд гарсан ажил гүйлгээ олон сургалтын төлбөрийг холбогдох стандарт, хууль, журмийн дагуу үнэн зөв бүртгэж тайлагнах

Эрсдэлүүд

Үнэн зөв, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл хангахгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Сургалтын төлбөрийн болон бусад орлогыг УСНББОУС-т болон, төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу үнэн зөв бүртгэж тайлагнан ажиллана.

Асуудал 4: Шууд зардлаар бүртгэсэн бараа материалын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Хичээл үйлдвэрлэлийн зардал амралтын газрын хоол, аж ахуйн материал, бүжгийн хувцас, ном хэвлүүлэхэд гарсан зардал гэх мэт нийт 82.2 сая төгрөгийн зардлыг бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан бараа материалын бүртгэлийн дансны заавраар бүртгэж хөтлөөгүй, УСНББОУС 12 "Бараа материал " стандартын 44 дүгээр зүйлд зааснаар"бараа материалыг борлуулах солилцох буюу хувиарлах үед тэдгээр бараа материалын дансны үнийг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв холбогдох орлого байхгүй бол барааг хувиарлах буюу холбогдох холбогдох үйлчилгээг үзүүлэхэд гарсан зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд бүртгэлээр тавих хяналт сулрах

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан бараа материалын бүртгэлийн дансны зааврын дагуу бараа материалыг бүртгэх, холбогдох стандарт мөрдөн ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Асуудал 5: Үндэслэлгүй олгосон цалингийн нэмэгдлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

